



## ХУУЛЬ САХИУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ, ШҮҮМЖ

**Н**ээлттэй Нийгэм Форумаас «Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хууль»-ийн төслийн хэлэлцүүлгийг төрлийн бус байгууллага, эрдэмтэн, судлаачдын оролцоотойгоор 2014 оны 11 дүгээр сард зохион байгууллаа. Хуулийн төсөлд өгсөн санал, шүүмжийг боловсруулахдаа НҮБ-ын хүний эрхийн гэрээ конвенц, жишиг стандарт, хүний эрхийн механизмуудаас өгсөн зөвлөмж, дүгнэлтийг анхааран судалсан. Мөн Эрүүгийн хэргэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай загвар хууль, бусад улс орны хууль тогтоомжийг харьцуулан үзлээ. Хэлэлцүүлгийн явцад гафсан санал, шүүмжийг нэгтгэн танилуулж байна.

Хуулийн төслийн хэлэлцүүлэгт хуулийн их дээд сургууль, судлаачдаас Н.Жинжиймаа, Д.Насанбат (МУИС-ийн Хууль зүйн ухааны сургууль), Н.Туяа (МУИС-ийн Хууль зүйн сургууль), Т.Оюунчимэг (судлаач, доктор), төрлийн бус байгууллагаас Г.Баярмаа (Монголын Чөлөөт Нийгмийн Ажилтны төв), Г.Ганбаясгах (Хүйсийн тэгш эрхийн төв), А.Гэрэл-Ундрям, Г.Даваабал (Монголын байгаль орчны төлөөх хуульчдын холбоо), К.Жанибек (Хөгжлийн хэлхээ), Д.Мөнхнаасан (Залуус эрүүл мэнд төв), Н.Нафандээцэг (Монголын байгаль эхийн аврал сан), Б.Нямбаяр (Хар тамхи мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг), А.Оюунчимэг (Булаг шанд гол мөрний эхийг хамгаалах сан), Д.Сафантуяа (Татварт иргэний хяналт), Ч.Сэмжидмаа (Сэтгэл зүйн мэдрэмж), Г.Төмөрмөнх (Ногоон соёл иргэншил хөгжил сан), Д.Цэнд-Аюуш (Хууль, хүний эрх төв), С.Цэндбаатар (Үндсэн уртлаг), Б.Энхсайхан, Д.Энхцэцэг (Хотын захын гэр хороолол хөгжил сан) болон Б.Хишигсайхан (Нээлттэй Нийгэм Форум) наф оролцлоо.

### Нэг. ЕРӨНХИЙ САНАЛ, ДҮГНЭЛТ

- Сахиулах гэдэг үг нь өөрөө үйлдүүлэх хэв шинжтэй тул «Хууль сахиулах тухай хууль» гэж нэрлэх, харин хууль сахиулагчийн тухайд хууль сахиулагчийн үйл ажиллагаа, хууль сахиулах тухайд хууль сахиулах ажиллагаа гэж нэрлэж хэвшиг нь зохистой.
- Төсөлд хууль сахиулах ажиллагааны зорилтыг тодорхойлоогүй тул нэмж тусгах нь зүйтэй.
- Хууль сахиулах үйл ажиллагааны зарчмыг үйл ажиллагаа болон эрхийн хүрээнд суулгаж өгсөн нь сайшаалтай ч тухайн ажиллагааны хууль ёсны эсэхийг тогтоох шалгуур, оролцогчдын эрхийн баталгаа болдгийг харгалzan зарчмыг тусгайлан оруулах шаардлагатай гэж үзэж байна.
- Практикаар шалгарсан, хүний эрхийн хэм хэмжээнд нийцсэн зарим зохицуулалтыг энэ хуулийн төсөлд дордуулан зохицуулсныг онцгойлон анхаарч үзэх шаардлагатай байна. Тухайлбал, шинжилгээ, нэгжлэг, үзлэг гэх мэт.
- Тухайн үйл ажиллагааг нэг мөр хэрэгжүүлэх үүднээс мөрдөн шалгах тодорхой ажиллагаа тус бүрийн ойлголт, үндэслэл, журмыг хуулийн төсөлд тодорхой тусгаж өгөх шаардлагатай.
- Тус хуулийн төсөлд иргэний өмгөөлүүлэх эрхэд шууд халдсан зохицуулалтыг нийтлэг байдлаар тусгасан нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээний зарчим, хэм хэмжээнд нийцэхгүй

байна. Мөн түүнчлэн төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй улсын өмгөөлөгчийг «жижүүрийн өмгөөлөгч» мэт үзэж, нөхөөс байдлаар ажиллагаанд татаж оролцуулахаар тусгасныг зөвтгөх аргагүй байна. Энэ тохиолдолд улсын өмгөөлөгчийн төлбөрийг хэрхэх, тус өмгөөлөгч нь үндсэн чиг үүргээ бүрэн дүүрэн, чанартай гүйцэтгэхэд энэ зохицуулалт хэрхэн нөлөө үзүүлэх зэргийг олон талаас нь судалж үзсэний үндсэн дээр зохицуулалтыг боловсронгуй болгох нь зүйтэй гэж үзэж байна.

7. Хуулийн төслийн зарим зохицуулалтыг бусад хуулийн зохицуулалттай уялдуулаагүй. Тухайлбал, мөрдөн шалгах нууц ажиллагааны тухай тогтоосон хэм хэмжээнүүд нь «Төрийн нууцын тухай», «Байгууллагын нууцын тухай» болон «Хувь хүний нууцын тухай» хуультай тус тус зөрчилдөж байна.
8. Нэр томъёоны тайлбарт зайлшгүй тайлбарлавал зохих нэр томъёог тайлбарлаагүйгээс хуулийг хэрэглэхэд эргэлзээ төрүүлэх, субъектив байдлаар хандах нөхцлийг бүрдүүлжээ. Тайлбар хийсэн зарим нэр томъёоны утга агуулга, найруулгыг эргэж харах нь зүйтэй байна.
9. Хуулийн бүтцийн логик дарааллыг зөв тогтоох, дугаарлалтын алдааг засах шаардлагатай байна.
10. Хуулийн төсөлд тодорхой субъектийг өөр өөрөөр нэрлэн оруулсан нь оновчтой биш болсныг анхаарч залруулах шаардлагатай байна. Тухайлбал, хүүхэд, насанд хүрээгүй хүн, өсвөр насны хүн, бага насны хүүхэд гэх мэт.

## Хоёр. ТУСГАЙ САНАЛ, ДҮГНЭЛТ

Зүйл, хэсэг		Үндэслэл	Санал
1	Хуулийн нэрийн тухайд	«Сахиулах» гэдэг үг өөрөө үйлдүүлэх хэв шинжтэй тул	«Хууль сахиулах тухай хууль» гэж нэрлэх
2	Холбогдох, зүйл, хэсэг	Хууль сахиулагчийн тухайд «хууль сахиулагчийн үйл ажиллагаа», хууль сахиулах тухайд «хууль сахиулах ажиллагаа» гэж нэрших	«үйл ажиллагаа», «үйл» гэсэн үгүүдийг хасах
3	1.3	Нэр томъёоны тайлбар хэстийг 1.5 дугаар зүйлийн дараа оруулах	
4	1.3.1	«дараах» гэсэн үгийг хасах	
5	1.3.1.2	«ийм зорилгоор» гэсэн үгийг хасах	
6	1.3.1.3	«хэрэг бүртгэх», «мөрдөн байцаах» гэсэн үгийг хасах	
7	1.3.1.6	«зөвшөөрсөн» гэж насанд хүрсэн, эрхийн бүрэн чадамжтай хүн өөрт нь холбогдуулан мөрдөн шалгах ажиллагаа явуулахтай санал нэг байгаагаа бичгээр илэрхийлснийг	
8	1.3.1.10	«эд хөрөнгөд» гэсэн үгийг нэмэх	
9	1.3.1.11	«Хувийн баримт бичиг» гэж МУ-ын иргэний үнэмлэх, гадаад паспорт, жолоодох эрхийн болон албаны үнэмлэх, гадаадын иргэний паспорт, тэдгээрийг орлох баримт бичгийг	
10	1.3.	Зайлшгүй оруулах нэр томъёоны тайлбар	«мөрдөгч» гэж хэргийг мөрдөн шалгах, зөрчлийг хянан шийдвэрлэх эрх бүхий хууль сахиулагчийг
			«мөрдөн шалгах нууц ажиллагаа» гэж Гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомжид заасан арга хэмжээг зохион байгуулахыг
11	1.7.2	Хоногоор тоолоход уг хугацаа эхэлсэн цаг, хоногийг тооцоонд оруулахгүй байх	Хувийн тэмдэгт, хууль ёсны төлөөлөгч, тоноглосон өрөө, зэвсэглэсэн болон зэвсэг хэрэглэн эсэргүүцэж болзошгүй хүн, бусад тусгай хэрэгсэл, хууль сахиулагчийн дотоод итгэл, хамгаалах хүн, цагдаагийн алба хаагч, мөрдлөг
12	1.7.3	Эцсийн гэсэн үгийг «сүүлчийн» гэж солих	

13	1.8.1	хууль сахиулагч гэсэн үгийн дараа «нь» - г оруулах	
14	1.8.3	баталгааг «бичгээр» гаргуулна гэх	
15	1.8.5, 1.8.6	Гүйцэтгэх ажлын тухай хууль /ГАтХ/-иар зохицуулагдах тул хасах.	
16	1.9.2	«эсхүл ажиллагааг дууссаны дараа өгнө» гэснийг хасах	
17	1.10.2	Хууль сахиулах албадууд онц ноцтой, ээдрээ төвөгтэй хэргүүдийг мөрдөн шалгах ажиллагааг харилцан тохиролцсоны үндсэн дээр албадын дарга нарын хамтарсан шийдвэрээр хамтран ажиллаж болно. Хууль сахиулах ажиллагааг хамтран хэрэгжүүлэх журмыг энэ хуулиар тогтоох	
18	2.1.2	Дугаарыг олгодог нэгдсэн бүртгэл байх шаардлагатайн ч дугаарыг дарга олгох нь оновчгүй хуваарилалт байна.	
19	2.1.3	Орон нутагт хэрэгжихэд хүндрэлтэй.	...24 цагийн дотор прокурорт мэдэгдэнэ.
20	2.2	Хуурамч мэдээлэл өгвөл хариуцлага хүлээлгэх тухай сануулах заалт оруулах	
21	2.2.2	Овог, эцэг, эхийн болон өөрийн нэр, регистрийн дугаар, ажлын болон оршин суугаа хаяг, холбоо барих утасны дугаар бичиж... гэж найруулах	
22	2.2.4	«... холбогдох баримт, материалыг хавсаргана» гэж өөрчлөх	
23	2.2.5	Гэр бүлийн хүчирхийлэл гэж нэмэх	
24	2.4.1	Хууль сахиулах байгууллага гомдол, мэдээллийг ... шилжүүлэх бол харьялах байгууллагад холбогдох баримтыг 24 цагийн дотор шилжүүлнэ.	
25	2.4.3	зайлшгүй ажиллагаа хийсэн байх шаардлагатай	«урьдчилан сэргийлэх» гэсэн үг нэмэх
26	2.5	буруу томъёолсон	Хэргээ илчлэн ирсэн тухай мэдээллийг хүлээн авах гэж өөрчлөх
27	2.6.1.1	Найруулгын алдаа	... бэлтгэсэн, завдсан, үйлдсэн тухай
28	2.6.2	Найруулгын алдаа	«мэдээллийг төлбөртэй авах тухай зарлаагүй боловч» гэсэн үгийг хасах
29	2.7.1.1-1.3, 1.6	«бусад» гэдэг үгийг хасах	
30	2.7.3.	«түргэн» гэдэг үгийг хасах	
31	2.8	мөрдөн шалгах ажиллагааг шуурхай, гүйцэд явуулахын тулд зөрчил, гэмт хэрэг илэрсэн болон оролцогчийн олонхи байгаа газар, эсхүл дагнасан чиг үүрэгтэй алба, нэгж явуулж болно.	
32	2.8.2.1	усан онгоц, усан онгоцны ахмад гадаадын иргэнд ийм эрх олгох нь хэр нийцтэй вэ?	
33	2.9.2.1	«өөрийн» гэсэн үгийг хасах	
34	2.9.3.3	«саналыг хүлээн авахаас» үгийг хасах	
35	2.9.4	Прокурорын гэсэн үгээс «ын» дагаврыг хасах	
36	2.9.1.	журамлавал зохих үйл, хэсгийг тодорхой болгох	... энэ хуулийн 2.10,2.11-р зүйлд заасан журмын
37	2.9	Дугаарлалт буруу	
38	2.9-2.11	Мөрдөн шалгах ажиллагааны явц, үр дүнг бэхжүүлэх журмыг мөрдөн шалгах ажиллагаа хэсэгт оруулах /2.9, 2.10, 2.11/	
39	2.11	Дуу-дүрс бичлэг хийхдээ тухайн тоног, төхөөрөмжид он, сар, өдөр, цаг, минутын тохиргоог заавал хийж, тохируулсан байна гэж нэмэх	
40	2.10.1.3	... зөвшөөрлөөр явуулж байгаа бол зөвшөөрсөн албан тушаалтны нэр, албан тушаал, зөвшөөрлийн дугаар, хүчинтэй хугацааг тэмдэглэнэ.	
41	2.10.1.5	/байршил/ гэдэг үгийг хаалтанд хийх	
42	2.10.1.8	«Хэрхэн» гэдэг үгийг хасах	оролцогчоос санал, хүсэлт гаргасан эсэх, түүнийг шийдвэрлэсэн талаар

43	2.11.3	Ойлгомжгүй байна. Нүцгэлж нэгжлэг хийх тохиолдолд дүрс бичлэг хийх зайлшгүй тохиолдол юу байхыг нэмж тусгах, өмгөөлөгч нь хүүхдийн өмнөөс зөвшөөрөл өгөх сүйкт мөн үү? Хүүхэд өөрөө энэ тухай саналаа хэлэх эрхгүй юу?	
44	2.12.3	«3» тоог хасах	
45	2.13	1.4. хүнийг айлан сүрдүүлэх, дарамтлах, хуурч мэхлэх 1.5. олон нийтэд айdas түгшүүр төрүүлэх, амгалан тайван байдлыг алдагдуулах гэсэн заалтыг нэмж тусгах	
46	2.14.2	Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд сэжигтний хүсэлтээр мөрдөн шалгах ажиллагаанд өмгөөлөгч байлцуулна.	
47	2.14.3	хугацаа бодитой бус	Хугацааг 24 цаг хүртэл гэж өөрчлөх
48	2.14.4	хасах	Өмгөөлөгч сонгох эрхийг хязгаарласан, төлбөрийн чадвартай сэжигтний тухайд бодитой бус тул улсын өмгөөлөгчдийн саналыг авах
49	2.15	Хохирогчийн аюулгүй байдлаа хамгаалуулах хүсэлт нь үндэслэлтэй бол Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу арга хэмжээ авна гэсэн нэмэлт оруулах.	
50	2.15.1	«тухай» гэсэн үгийг хасах	Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч (цаашид «Хүсэлт гаргагч» гэх) мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах, аюулгүй байдлыг хамгаалах болон хуулиар олгогдсон эрхээ ханггуулахтай холбоотой хүсэлтийг хууль сахиулагчид гаргаж болно.
51	2.15.3	Хууль сахиулагч өөрийн шийдвэрийг 24 цагийн дотор хүсэлт гаргагчид танилцуулна.	
52	2.16.2	Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч нь мөрдөн шалгах ажиллагааны нууцад хамаарах болон мөрдөн шалгах нууц ажиллагааны талаар дараах мэдээлэл авахаар шаардахыг хориглоно.	
53	2.16.3	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нийцүүлэн томъёолох	
54	2.16.4	1.11-р зүйлийн 4 дэх хэсэг гэж байхгүй.	
55	3.1.1	Хууль сахиулагч хүний нэр, хаяг, тодорхой үйл ажиллагаа явуулах эрхтэй эсэхийг тодруулахаар биеийн байцаалт, бусад бичиг баримтыг дор дурдсан тохиолдолд шаардах эрхтэй. Бичиг баримт шалгах тохиолдолд эд зүйл, бичиг баримт нь зөрчил, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, эсхүү үйлдэх замаар олж авсан эсэхийг тодруулахаар гэж санаа нэмэх	
56	3.1.2	Хууль сахиулагч хүний биеийн байцаалт, бичиг баримтыг шалгахдаа нүүрээ хаасан зүйлийг авах, нүүрээ халхлах аливаа үйлдэл хийхгүй байхыг шаардах эрхтэй.	
57	3.1.4	Хууль сахиулагч биеийн байцаалт шалгуулагчийг уг ажиллагаа дуустал тухайн газраас явахыг хориглох, хууль сахиулах байгууллагад очиж шалгуулах шаардлага тавьж болно.	
58	3.4.4	Хууль сахиулагч бүлэг хүнд шаардлага тавих тохиолдолд чанга яригч ашиглана.	
59	3.5.1	Хууль сахиулагч тээврийн хэрэгслийн жолоочийг согтууруулах ундаа, сэтгэцэд нөлөөлөх, мансууруулах бодис хэрэглэсэн байж болзошгүй үед дараах аргаар шалгаж болно:	
60	3.5.2	Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар тогтоох боломжгүй, эсхүүл шалгуулахаас татгалзсан тохиолдолд мэргэжлийн байгууллагаар шинжилгээнд зориулж цус, шүлс, шээнсээс дээж авхуулна.	
61	3.6	хасах	
62	3.7	Согтуурсан, мансуурсан хүнд эмнэлгийн тусlamж үзүүлэх	
	3.7.2.1, 3.7.2.2	Нэгтгэж «хамгаалах хүн хүлээн авахаас татгалзсан»	
	3.7.3	Хууль сахиулагч энэ хуулийн 5.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацаанд албадан саатуулагдсан согтуурах, мансуурах донтой болон сэтгэцийн өвчтэй хүнд Согтуурах, мансуурах донтой өвчтэй хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд <sup>1</sup> заасан арга хэмжээг авна.	

	3.8	Хууль сахиулагч бусдын орон байрны халдашгүй байдлыг хангаж ажиллана.	
	3.9.1.2	хугацаа дуусмагц, эсхүл шаардлагыг эсэргүүцсэн тохиолдолд албадлага хэрэглэхийг анхааруулах	
63	3.9.1.3	Хэл, ярианы бэрхшээлтэй хүнд хэрхэн мэдэгдэх талаар нэмж тусгах	
64	3.9.4	Хамгаалах арга хэмжээ авах үүрэгтэй гэж өөрчлөх	
65	3.12.4	Тээврийн хэрэгслийг зогсоон шалгах явцад жолооч, зорчигчийг баривчлах, тээврийн хэрэгсэл, эд зүйлд үзлэг, нэгжлэг хийх, хураан авах үндэслэл илэрвэл энэ хуульд заасан баривчлах, үзлэг, нэгжлэг хийх, хураан авах журмын дагуу ажиллагааг явуулна гэж өөрчлөх	
66	3.15	Сул уг	1.1-1.5 дахь өгүүлбэрүүдээс бол гэсэн үгийг хасах
67	3.15.1.5	Найруулгын алдаатай	тээврийн хэрэгсэл техникийн шаардлага хангаагүй, бүрэн бус
68	3.16	«учруулсан» гэсэн үгийн с-ийг хасах	
69	3.16.2	«автомашин ашиглан» гэснийг автомашинаар гэж солих	
70	3.17.	«байруулах» гэснийг «байршуулах» гэж солих	
71	4.1.4	Хүүхдээс тайлбар авахад хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлийг урьдчилан бичгээр авч, байлцуулна.	
72	4.2.4.1 4.2.4.2	Хүний эрх чөлөөнд халдах үндэслэл болохоор байх тул хасах	
73	4.2.5.1	«хамгийн богино хугацаанд» гэсэнд тайлбар хийх	
74	4.2.6	Хоёр дахь өгүүлбэрийг «Нэгжлэг хийсэн тухай эзэмшигч, оршин суугч, эсхүл засаг захиргааны нэгжийн ажилтанд ажиллагааг явуулснаас хойш 24 цагийн дотор мэдэгдэж шаардлагатай бол хамгаалах арга хэмжээ авна» гэж өөрчлөх	
75	4.2.8	Хураан авсан эд зүйлийг дуу, дүрсний бичлэгээр баримтжуулна гэсэн нэмэлт хийх	
76	4.3.2-6	Үзлэг, нэгжлэгийн алийг нь хийх гэж байгаагаа тодорхой болгох, нүцгэн биед нэгжлэг хийх гэдэг нь оновчтой бус	
77	4.3.2	«хүний биед нэвтэрч» гэсэн нь огт зохимжгүй томъёолол болсон тул засах	
78	4.4.1	Хууль сахиулагч тээврийн хэрэгсэлд нэгжлэг хийхдээ энэ хуулийн 4.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан журмаар гадна, дотор талын эд анги, хэрэглэгдэхүүнийг салган шалгаж болно. Мөн «Ингэхдээ тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүйгээр, хэрэв алдагдуулсан бол нэгжлэг хийхийн өмнөх байдалд оруулах зардлыг төлнө. Тээврийн хэрэгсэлд нэгжлэг хийхдээ дуу-дүрсний бичлэгээр баримтжуулна.» гэж нэмэх	
79	4.6.2.1	эзэмшигч өөрөө зөвшөөрнө гэдэг үнэмшилгүй	Хасах
80	4.6.2.2	Эд зүйлийг нуух, устгах, өөрчлөх, хуурамчаар үйлдэх, эрх шилжүүлэх зэрэг бодит эрсдэл байгаа	
81	4.6.7	«Хууль сахиулагч хураан авсан эд зүйлийн төрөл, шинж байдал, тоо ширхгийг тусгасан жагсаалтыг үйлдэж, эд зүйлээ хураалгасан, ажиллагаанд байлцсан хүний гарын үсэг, эсхүл хурууны хээгээр баталгаажуулмагц жагсаалтын хувийг эд зүйлийн эзэмшигч, эсхүл түүний өмгөөлөгчид гардуулна.» гэж найруулах	
82	4.7.2	бусад боломжтой хүн гэж хэн бэ? Ямар шалтгаанаар хувь хүн үүрэг хүлээх ёстой нь тодорхойгүй	«бусад боломжтой хүнд хадгалах, хамгаалах үүрэг хүлээлгэнэ» гэснийг хасах.
83	4.8.1.1	1.1. үл хөдлөх хөрөнгө, үнэт цаас, тээврийн хэрэгслийн бүртгэл, дансны гүйлгээ, хувийн хадгаламжийг хянах	

<sup>1</sup> Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хууль - «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн 2000 оны №6(143)-д нийтлэгдсэн.

84	4.8.1.2	1.2. эд хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг түдгэлзүүлэх, дансны болон хадгаламжийн орлого, зарлагын хөдөлгөөнийг дангаар, эсхүл хамтад нь зогсоохыг эрх бүхий байгууллагад даалгах	
85	4.8.2	ГАтХ-иар зохицуулагдах тул хасах.	
86	4.8.3	«Энэ тохиолдолд ажиллагааг нууцаар явуулж болно» гэсэн өгүүлбэрийг хасах, энэ нь ГАтХ-иар зохицуулагдана.	
87	4.9.1.1	«... талаарх мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах» гэж өөрчлөх	
88	4.9.2	Сүлжээнд нэвтрэч хянах ажиллагааг гүйцэтгэх ажилтан явуулна, энэ нь ГАтХ-иар зохицуулагдах тул хасах	
89	4.9.4	2 дахь хэсэгтэй давхцсан учир хасах	
90	4.10.3	Хураан авсан цахим мэдээлэл, цахим төхөөрөмжид энэ хуулийн 4.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр (өөрийн зөвшөөрлөөр болон хойшлуулшгүй тохиолдолд) шүүгчийн зөвшөөрөлгүй, хөндлөнгийн гэрч байлцуулан нэвтрэн шалгаж болно.	
91	4.11.6.	ГАтХ-иар зохицуулагдах тул хасах	
92	4.12.2	«Таньж олуулах ажиллагааны өмнө хүн, мал, амьтан, эд зүйлийг ямар онцлог, шинж тэмдгээр таньж болохыг уг ажиллагаанд оролцох гэж байгаа хүнээс урьдчилан асууж, энэ тухай тэмдэглэл үйлдсэн байна.» гэсэн нэмэлт хийх	
93	4.12.13	«Таньж олох гэж байгаа хүн хүсвэл танигдаж байгаа хүнд мэдэгдэхгүйгээр таньж олох боломж олгоно.» гэж найруулах	
94	4.14	Нэмэлт эрэн сурвалжлах ажиллагаа эхлэхгүй цаг хугацаа алддаг. Тиймээс энэ үйл ажиллагааг процессжуулах шаардлагатай.	Эрэн сурвалжлах ажиллагаа явуулж өгөх хүсэлтийг хүлээн авмагц 24 цагийн дотор ажиллагааг эхлүүлнэ.
95	4.14.1	Хууль сахиулах байгууллага шүүхийн шийдвэр, прокурорын даалгавраар эсхүл чиг үүргийнхээ дагуу эрэн сурвалжлах ажиллагааг явуулна.	
96	4.15	ГАтХ-иар ажиглалт хийхийг биечилсэн сурвалжлага гэдэг.	Биечилсэн сурвалжлага
97	4.15.1	Ердийн гэдэг нь сул үг	Хууль сахиулагч хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл, баримтыг олж илрүүлэх зорилгоор олон нийтийн газарт тодорхой хүн, объектод биечилсэн сурвалжлага явуулна.
98	4.15.2	ГАтХ-иар зохицуулагдана	хасах
99	4.16.2	«бусад хүнд» гэдгийг тодорхой томъёолох	
100	4.19	ГАтХ-иар зохицуулагдана	бүхэлд нь хасах
101	4.20	4.20. Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах журам гээд энэ журамд: 4.15 /ажиглалт явуулах/ биечилсэн сурвалжлага, 4.16 хяналт тогтоох, 4.17 хяналттай хүргэлт, 4.18 хяналтын худалдан авалтын журмыг үүнд багтаан журамлах. Мөн «мөрдөн шалгах нууц ажиллагааг МУ-ын Гүйцэтгэх ажлын тухай хууль, холбогдох хууль тогтоомжид үндэслэн явуулна.» гэж нэмэх	
102	4.21	Зүйлийн оноосон нэр нь үйл ажиллагааны агуулгатай давхцсан.	Мөрдлөг эсхүл үзлэг гэж нэрлэх. Мөрдлөгийн ажиллагааг дуу, дүрс бичлэг хийж, тэмдэглэл үйлдэн бэхжүүлнэ.
103	4.21.3.12	найруулга	Мөрдлөг явуулж байгаа газрыг цахилгаанаар тасралтгүй хангахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг болгох
104	4.21.5	Тухайн ажиллагаатай уялдахгүй байна. Мөрдлөг өөрөө шүүгчийн зөвшөөрөлгүй явагддаг.	

105	4.21.6	найруулга	Хэргийн газрын мөрдлөг явуулахаар орон байр, эзэмшил газар, агуулах саванд нэвтрэн орохдоо эзэмшигчийг нь байлцуулна.
106	4.21.7	Зүйл заалт буруу ишилсэн.	3 дахь гэдгийг 6 дахь гэж өөрчлөх
107	4.23.2	ГАТХ-иар зохицуулагдана.	хасах
108	4.23.8	Холбогдох заалтыг ишлэх	
109	4.23, 4.24, 4.25	Хуучин хуулийн заалтуудыг судалж, оруулах	
110	5.1.1	Агуулгын хувьд алдаатай	Хууль сахиулах байгууллагад олон төрлийн байгууллага харьялагдах тул дарга нь улсын ерөнхий байцаагч байна гэсэн нь буруу.
111	5.1.3.1	найруулга	хууль сахиулах байгууллагын улсын байцаагч нь энэ хуульд заасан мөрдөн шалгах ажиллагааг
112	5.1.5	найруулга	Улсын байцаагч нь мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулахыг хориглоно.
113	5.3.1	Улсын байцаагчид маш том эрх олгожээ.	Зөрчилд шийтгэл оногдуулахдаа хураан авсан, битүүмжилсэн эд хөрөнгийг буцаан олгох, улсын орлого болгох эсэхийг шүүхээр шийдвэрлүүлнэ.
114	5.8.3	Мансуурах донтой, сэтгэцийн өвчтэй хүнийг saatuuлах нь амь насанд нь аюултай тул saatuuлах биш эмнэлгийн байгууллагад хүргэх, зөрчил гаргасан согтуу хүнийг эрүүлжүүлэх арга хэмжээ авах нь зохимжтой. «Цагдаагийн албаны байцаагч» гэж хэн бэ?	
115	6.1.3	Найруулга	Хууль сахиулагч баривчлах саналын хамт баривчлах үндэслэлийг нотолсон баримтыг хавсаргана.
116	6.1.4	найруулга	Прокурор, шүүхээс зөвшөөрөл авахад шаардлагатай нэмэлт баримтыг цуглуулах талаар хууль сахиулагчид даалгаж болно
117	6.4.2.3	Өмгөөлөгчөөс гэдэг үгийг хасах	
118	6.4.6	Холбогдох зүйлийг ишлэх	
119	6.4.8	Төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хуульд нийцүүлэх	
120	6.4.12	«даруй» гэдгийг тодорхой хугацаагаар солих	
121	6.4.13	Шашин шүтэх эрхийг хангах	Эрүүл мэнд, шашин шүтлэгийн улмаас тусгай хоол хүнсээр хангагдах, мөргөл үйлдэх хүсэлтийг saatuuлах байрны захиргаа шийдвэрлэнэ.
122	6.4.15.1	Найруулга	баривчлагдсан хүний асрамжид байдаг бага насы хүүхэд, өндөр настай эцэг, эх, бусад хүнийг асран хамгаалах, харгалзан дэмжүүлэхээр тэдний төрөл төрөгсдөд, эсхүл асрамж, халамжийн байгууллагад түр шилжүүлэх;
123	6.4.16	Тодорхой бус заасан тул	Хууль сахиулагч сэжигтэнд эрүүл мэндийн шаардлагатай тусламж үзүүлсэн бол энэ тухай сэжигтний ар гэр, өмгөөлөгчид 3 цагийн дотор мэдэгдэнэ.
124	6.6.3.4	«эх хэл, эсхүл өөрийн сайн мэддэг хэлээр мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрчийн туслалцааг үнэ төлбөргүй авах» тохиолдолд орчуулагч, хэлмэрчийн хөлсийг хэрхэн төлөхийг тодорхой болгох	
125	6.6.4	Улсын өмгөөлөгч оролцуулах нөхцлийг холбогдох хуультай нийцүүлэх	

126	6.6.5	Өмгөөлүүлэх эрхийг дордуулсан заалт	
127	6.6.6	Үгийн сонголт буруу	
128	6.6.10	Бусад хүний өгсөн тайлбарыг сэжигтэнд танилцуулах нь ёс зүйгүй, тайлбар өгөгчийн эрх, ашиг сонирхолд харш үйлдэл бөгөөд аюулгүй байдал талаасаа ч эрсдэлтэй алхам юм.	
129	6.7.3	Хүүхдийн сэтгэхүйн онцлогийг харгалзах	Нэг удаагийн мэдүүлэг авах ажиллагаа нийт 3 цагаас хэтэрч болохгүй.
130	6.10	Сэжигтнийг албадан ирүүлэх талаар нэмж тусгах	
131	7.1.2.7	«үндэслэл бүхий сэжиг» байвал гэсэн санааг нэмж тусгах	
132	7.2.1	Эрх бүхий албан тушаалтныг тодорхой болгох	Цагдаагийн ерөнхий газрын дарга, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр доор дурдсан тохиолдолд согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдаалахыг хориглож болно.
133	7.4.2	Хууль гэж засах	
134	8.2.3	Эрх бүхий албан тушаалтныг тодорхой болгох	Хууль сахиулах байгууллагын даргын шийдвэрээр албан хэрэгцээнд хүлээн авч бүртгэсэн тусгай хэрэгсэл, галт зэвсэг, сум, бусад хэрэгслийг эрх олгогдсон хууль сахиулагч хэрэглэнэ.
135	8.2.5	Хууль сахиулах байгууллага, хууль сахиулагч албан үүргээ гүйцэтгэхдээ биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх явцад хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахаас аль болох зайлсхийнэ. Хэрвээ амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэн, эмнэлгийн байгууллагад мэдэгдэх, хүргэх, энэ тухай шууд захирах даргадаа, шууд захирах дарга нь прокурорт мэдэгдэнэ.	
136	8.4.1.3	Бусад гэдгийг тодруулах эсхүл хасах	
137	8.6.2	«тахир дутуу» гэдэг үгийг «хөгжлийн бэрхшээлтэй» гэж солих	
138	8.8.2.1	«эсэргүүцсэн» гэдэг үгийг хасах	
139	8.8.2.6	«нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчиж» гэдгийг тайлбарлах	
140	8.8.3.1	chanга яригчаар анхааруулах тухай нэмж тусгах	
141	8.10.1.10	«хамгаалсан, хориглосон» гэсэн үгүүдийг хасах	
142	8.10.1.11	«устгахад» гэдэг үгийг «номхотгоход» гэдэг үгээр солих	
143	8.11.2	«бололцоотой бүх тохиолдолд» гэдгийг тодорхой тайлбарлах, эсхүл, бололцоогүй тохиолдлыг жагсаах	

Дугаарыг эрхэлсэн: Т.ОЮУНЧИМЭГ  
Судлаач, Доктор

Дугаарт оролцсон: Н.ТУЯА  
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Практик  
сургалтын төвийн эрхлэгч  
Б.ХИШИГСАЙХАН  
ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер  
Д.ЦЭНД-АЮУШ  
«Хууль хүний эрх» төвийн Тэргүүн

Хаяг: Жамъян гүний гудамж - 5/1  
Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар - 14240  
Монгол Улс

Утас: 976-11-313207  
Факс: 976-11-324857  
Вэб: [www.forum.mn](http://www.forum.mn)  
И-мэйл: osf@forum.mn